

Стандартчилал, хэмжил зүйн газрын  
даргын тушаал

2013 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/109

Улаанбаатар хот

Гэрчилгээ, мэдэгдлийн загвар, гэрчилгээ  
бичих журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4, 16 дугаар зүйлийн 16.2.9 дэх заалт, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 1999 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийх журам, зохион байгуулалт”-ын 1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээний загварыг 1 дүгээр, хэмжих хэрэгсэл ашиглалтад тэнцэхгүй болохыг тогтоосон мэдэгдлийн загварыг 2 дугаар, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ бичих журмыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ, хэмжих хэрэгсэл ашиглалтад тэнцэхгүй болохыг тогтоосон мэдэгдэл хэвлүүлэх зардлыг байгууллагын жил бүрийн урсгал зардалд тусган санхүүжүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Э.Эрхэмбаяр/, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ бичих журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэмжил зүйн хэлтэс /Г.Зоригоо/-т үүрэг болгосугай.

3. Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ бичих журмыг дээрх загварын гэрчилгээг хэрэглэж эхлэх өдрөөс мөрдсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн даргын 2009 оны 76 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан үнэт цаастай адилтгах баримт, гэрчилгээний жагсаалтын хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээтэй холбогдох заалт, 2 дугаар хавсралтаар баталсан хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээний загварыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭНХТАЙВАН

## **ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ БИЧИХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалтын дагуу хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээг бичихэд энэхүү журмыг баримтлана.

1.2 Шалгалтын үр дүнгийн дагуу стандартын шаардлага хангаж тэнцсэн хэмжих хэрэгсэлд Хэмжил зүйн төв байгууллагаас баталсан загвар бүхий баталгаажуулалтын гэрчилгээг олгоно.

1.3 Баталгаажуулалтын гэрчилгээг Хэмжил зүйн төв байгууллагаас хэмжүүрийн улсын шалгагчийн эрх олгосон ажилтан өөрөө бичнэ.

1.4 Хэмжил зүйн төв байгууллагаас олгосон баталгаажуулалтын гэрчилгээг дугаарын дараалал (өгсөх дугаар)-аар бичнэ.

1.5 Хэмжих хэрэгслийг шалгаж баталгааны тэмдэг дарсан дарууд гэрчилгээ бичнэ. Шалгаж баталгааны тэмдэг дарсан дарууд гэрчилгээг бичих боломжгүй бол ажлын 2 хоногт багтаан бичнэ.

1.6 Хэмжих хэрэгслийг шалгахгүйгээр баталгаажуулалтын гэрчилгээ олгох, сунгахыг хориглоно.

1.7 Мэдээлэл нь засвартай, эсхүл буруу, дутуу бичсэн баталгаажуулалтын гэрчилгээг хэрэглэгчдэд олгохыг хориглоно.

1.8 Мэдээлэл бичигдээгүй гэрчилгээн дээр улсын шалгагчийн тэмдэг дарахыг хориглоно.

1.9 Улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн дэлгэрэнгүй жагсаалтад заасан хэмжих хэрэгсэл (худалдааны туухайнаас бусад) тус бүр дээр гэрчилгээ бичнэ.

### **Хоёр. Баталгаажуулалтын гэрчилгээг бичих**

3.1 Хэмжүүрийн улсын шалгагч нь баталгаажуулсан хэмжих хэрэгслийн дараах мэдээллийг баталгаажуулалтын гэрчилгээн дээр үнэн зөв, бүрэн, ямар нэгэн засваргүйгээр заавал бичнэ. Үүнд:

**3.1.1 Хэрэглэгчийн нэр:** Хэрэглэгчийн нэрийг тодорхой, аль болох дэлгэрэнгүй бичнэ. Хэмжих хэрэгсэл нь цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмч, эсхүл Хэмжил зүйн төв байгууллагаас хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл (худалдах) авсан хуулийн этгээдийн худалдах зорилгоор баталгаажуулж байгаа хэмжих хэрэгсэл бол хэрэглэгчийн нэрийг бичихгүй байж болно.

**3.1.2 Хэмжих хэрэгслийн загвар:** Хэмжих хэрэгслийн улсын бүртгэлд бүртгэгдсэн болон Хэмжил зүйн төв байгууллагын шийдвэрээр загварыг нь шууд хүлээн зөвшөөрсөн хэмжих хэрэгслийн загварыг бичнэ. Загварын бичлэгийг товчлон бичихийг хориглоно.

**3.1.3 Хэмжих хэрэгслийн хэмжих хязгаар:** Хэмжих хэрэгсэл нь зөвшөөрөгдөх хамгийн их алдааны хязгаарт тасралтгүй ажиллах боломжтой хэвийн хэмжих хязгаарыг бичнэ.

**3.1.4 Хэмжих хэрэгслийн дугаар:** Хэмжих хэрэгслийн загварын хувьд дахин давтагдахгүй байх цуврал дугаарыг бичнэ.

**3.1.5 Хэмжих хэрэгслийн нэр:** Хэмжих хэрэгслийн хийц, хэмжих орчин, ажиллах зарчим, зориулалт гэх мэт онцлог байдлаас нь хамааран Улсын баталгаажуулалтад заавал хамруулах хэмжих хэрэгслийн дэлгэрэнгүй жагсаалтад заасан хэмжих хэрэгслийн нэртэй нийцүүлэн бичнэ.

**3.1.6 Лацны төрөл, дугаар:** Хэмжих хэрэгсэл дээр лац ломбо ашиглан битүүмжилсэн бол улсын шалгагчийн тэмдгийн дугаарыг бичнэ. Харин наах зориулалттай цаасан баталгааны тэмдгээр битүүмжилсэн бол цаасан баталгааны тэмдгийн цуврал дугаарыг бичнэ.

**3.1.7 Баталгаа хүчинтэй байх огноо:** Хэмжих хэрэгслийг баталгаажуулсан огноо дээр Хэмжил зүйн төв байгууллагаас баталсан хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хоорондын хугацааг нэмсэн огноог бичнэ.

**3.1.8 Шалгалтын дараах заалт:** Шалгалтын дараах хэмжих хэрэгслийн заалтыг бичнэ.

**3.1.9 Лабораторийн тэмдэг:** Ямар хэмжлийн төрөлд хамаарахаас шалтгаалан тухайн хэмжлийн төрлийг хамаарах лабораторийн тэмдгийг дарна.

**3.1.10 Улсын шалгагчийн тэмдэг, гарын үсэг:** Хэмжих хэрэгсэл баталгаажуулсан улсын шалгагч гарын үсэг зурж, тухайн хэмжүүрийн улсын шалгагчид Хэмжил зүйн төв байгууллагаас олгосон хувийн дугаар бүхий улсын шалгагчийн тэмдгийг дарна.

**3.1.11 Баталгаажуулсан огноо:** Хэмжих хэрэгслийг баталгаажуулсан огноог бичнэ.

**3.1.12 Тусгай тэмдэглэл:** Баталгаажуулсан хэмжих хэрэгслийн хийц, хэмжих орчин, ажиллах зарчим, зориулалт гэх мэт онцлог байдлаас нь хамааран гэрчилгээн дээр зайлшгүй бичих шаардлагатай техникийн болон хэмжил зүйн үзүүлэлт, бусад мэдээллийг бичнэ. Тусгай тэмдэглэл бичсэн тохиолдолд улсын шалгагчийн гарын үсэг зурж тэмдэг даран огноог бичнэ.

**3.1.13 Баталгаажуулалтын төлбөр:** Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу Хэмжил зүйн асуудал хариуцсан Монгол улсын сайдын баталсан хэмжих хэрэгслийн улсын шалгалт, баталгаажуулалтын төлбөрийн хэмжээг тоо болон үсгээр бичнэ.

#### **Дөрөв. Гэрчилгээний бичилтэд тавих хяналт**

6.1 Хэмжил зүйн асуудал хариуцсан үндсэн нэгжийн даргын баталсан удирдамжийн дагуу хэмжил зүйн хяналтын улсын байцаагч, холбогдох нэгжийн дарга баталгаажуулалтын гэрчилгээний бичилтэд хяналт тавина.

#### **Долоо. Хүлээлгэх хариуцлага**

7.1 Энэ журмыг зөрчсөн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хэмжүүрийн улсын шалгагчид дараахь хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:

7.1.1 Анх удаа зөрчил гаргасан тохиолдолд сануулах;

7.1.2 Хоёр удаа зөрчвөл албан тушаалын цалингийн хэмжээг 6 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах;

7.1.3 Гурав болон түүнээс дээш удаа зөрчсөн, санхүүгийн зөрчил гаргасан тохиолдолд ажлаас халах;

7.2 Энэ журмыг зөрчсөн хэмжүүрийн улсын шалгагчийн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй, санхүүгийн зөрчилтэй холбоотой бол хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулна.

----- о О о -----